

“Завханбаялаг” ХК-ын 2020 оны үйл ажиллагааны тайлан

Завханбаялаг ХК-ний 2020 оны зорилго зорилтууд, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлууд хийгдэж компанийн үйлдвэрлэлтийг тасралтгүй явуулсан байна.

1. Шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр

- Шинэ технологиор лекор үйлдвэрлэж цагаан идээ боловсруулан ааруул, шимиийн архи үйлдвэрлэж худалдаанд гаргасан.
- Жимсний чанамалын найрлага дахь жимсний эзлэх хувийг ихэсгэн амт чанарыг сайжруулсан байна.
- Цаашид байгалийн гаралтай жимс жимсгэнийг үйлдвэрлэлийн гол чиглэл болгох үүднээс чацаргана жимсний шүүс исгэж жимсний охь үйлдвэрлэх, нэг удаагийн хэрэглээний савалгаатай жимсний шүүс үйлдвэрлэх, төрөл бүрийн жимс хатааж цай үйлдвэрлэх ажлууд туршилтын шатанд явагдаж үйлдвэрлэлд нэвтрүүлж жимсний цай, өтгөн шүүс үйлдвэрлэгдэж байна.
- Чонын элэг, аньс, нэрс, үхрийн нүд зэрэг байгалийн зэрлэг жимсийг хольж олон жимсний чанамалыг үйлдвэрлэж байна.
- Үйлдвэрлэлийн гар ажиллагааг хөнгөвчлөх хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд цэвэр ус ундаа савлах шугам, тоног төхөөрөмжөөр хангасан.

2 .Чанар удирдлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр

- НАССР-ын чанарын удирдлагын шаардлагуудыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтүүрэн ашиглахыг зорилго болгон ажиллаж байна. Үйлдвэрийн дотоод хяналтын лаборатори нь MNS ISO 17025 стандартын шаардлагын дагуу СХЗГ-ын итгэмжлэлийн давтан үнэлгээнд орж итгэмжлэгдсэн лабораторийн эрхийг 2 жилээр авсан.
- COVID 19 өвчлөлтэй холбоотой үйлдвэрийн орчны болон ажилчдын ариун цэвэрт маш ихээр анхаарч ариутгал халдвартгуйжүүлэлтийн ажил хийгдэж байна.
- Ажлын чанарыг өдөр бүр үнэлэх шалгалтын хуудсыг цех тасаг ажлын байр нийтийн эзэмшлийн газар, дэлгүүрүүдэд байрлуулж хяналт тавиж байгаа нь үр дүнгээ өгч байна.
- Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанар стандартын мөрдөлтөнд улирал бүр хөндлөнгийн хяналт хийлгэн ажиллаж байна.

3. Үйлдвэрлэлийн зохистой дадал, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сайжруулах ба нийгмийн асуудлыг шийдэх чиглэлээр

Ажилтан ажилчдад үнэгүй халуун хоол цай өгч-33,0 сая , хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, нормын сүү зэргээр ханган нийт ажиллагсдыг ЭМ-ийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулав. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслэлтийг жилд 2 удаа тавьж олгов. Захиргаа аж ахуйн ажилчдад зориулж 1 ш компьютер, принтер –г 5,0 сая төгрөгөөр, үйлдвэрийн тоног төхөөрөмж 107,4 сая төгрөгөөр худалдан авсан ба 19,0 сая төгрөгний урсгал засвар хийж ажиллах орчин нөхцлийг сайжруулжээ. Компанийн нийт ажилтан ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор хурууны хээгээр цагын бүртгэлийг хийж, дотоод журмын хэрэгжилтэнд хяналт тавих системийг тогтоож, ХАБЭА-н сургалтанд нийт ажиллагсдыг 2 удаа хүнсний аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтанд 3 удаа, МШӨ, ҮО сэдэвт чадавхжуулах сургалтанд 1 ажилтанг хамруулсан байна.

Мөн ажилтан ажилчдын ажлын үр дүнгээр нь жилийн эцэст шалгаруулж 3 хүн гадаадад явах эрхээр шагнагдаж тэргүүний ажилчдаа шалгаруулан шагнал урамшуулал олгож, ажилчдын шинэ жилийн баярыг тэмдэглэх, өндөр настангуудад болон ажилчдын хүүхдэд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг өгчээ

2020 онд худалдаа үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах УБ хотод салбар дэлгүүр, Баялаг органик үйлдвэрийн байр ашиглалтанд оруулан салбар үйлдвэрээ байгуулан ажиллаж байна.

4.Туслах аж ахуйн талаар

Компанийн чацарганы талбайгаас 5,1 тонн, Хар бутны чацаргана 4,9 тн, Ховд Улаанбаатараас 6,6 тн нийт 16,6 тонн тонн чацаргана худалдан авсан нь чацарганы талбай дээрх хортон шавьж, мөн сийрэгжүүлэх шаарлагатай байгаа нь харагдаж байна., 12 машин өвс бэлтгэж худалдсан. Нийт нэрс чацаргана, чоныг элэг, аньс, гишүүн 22,6 тонн жимс авсан

2020 онд нийт жимс нийлүүлэгч нартай хамтран ажиллаж бөөнөөр 1,9 тонн нэрс жимс, 1,8 тн чонын элэг жимс, 2,3 кг анис жимс худалдан авч жимсний түүхий эдийн нөөцөө бүрдүүлж. Ажилчидын хүчээр цайны ургамал жимсийг түүж бэлтгэжээ.

5 .Бүтээгдэхүүний борлуулалтын талаар

Өөрийн нэрийн 2 дэлгүүр, аймгийн төвд Оргил худалдааны төв, баруун бүсийн худалдааны төв, Баянбүрд супермаркет, Баавгайт, Оргил-ням Тосонцэнгэл сумд Өвөгдэй дэлгүүр, Yr-Or ,Нэмрөг сумын Харз, Түдэвтэй сумын Шар нуруут дэлгүүр, Тэлмэн сумын Тэсийн гол дэлгүүр, Отгон сумын Баатарсүрэн, Цагаанчулут сумын Батмөнх, Цагаанхайрхан сумын Биндэрхайрхан зэрэг дэлгүүрүүдтэй хамтран ажиллажээ.

УБ хотын төлөөлөгчийн газраар дамжуулж худалдаа хийж борлуулалтын хэмжээ өмнөх оноос 45-50 хувиар өслөө ажиллаж бараа бүтээгдэхүүнээ борлуулж байна.

Мөн аймгийн төвийн 1,2 -р цэцэрлэг,3,4-р 10жилийн сургууль, Дэвшил сургуультай гэрээгээр хамтран ажилладаг ба бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Аймгийн халамжийн хэлтэсээс зарласан Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох тендерт оролцон шалгарч нийт 38 өрхийн 55,0 сая төгрөгний хүнсний бараа бүтээгдэхүүн борлуулсан байна.

6. Бүтээгдэхүүний зар сурталчилгаа марктенгийг сайжруулах чиглэлээр

2020 онд 5 удаа телевизийн зар сурталчилгаа хийлгэн бараа бүтээгдэхүүний хүлээлт үүсгэн ажилласны зэрэгцээ, Гудамж тайлбайд том болон жижиг сурталчилгааны самбарыг шинэчлэн байршуулж ажиллав.

2020 оны ажлаа аймагтаа үнэлүүлж Дэлхийн чанарын өдрөөр аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэсээс олгодог 2020 оны “ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭГЧ БАЙГУУЛЛАГА” -аар орон нутагт болсон үзэсгэлэн худалдаанд шилдэг хэвийн боов, жимсний вакус зэрэг бүтээгдэхүүнүүд Хүнсний үйлдвэрийн шилдэг бүтээгдэхүүн цолоор шалгарсан байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

1. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах ажилд дэвшил гаргаж чанарын хяналтын цогц систем тогтоож мөрдүүлж эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэх чиглэлээр анхаарч, бүх цехд үйлдвэрлэлийн зохистой дадалыг хэвшүүлнэ
2. Дотоод нөөц бололцоог ашиглан шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх Үүнд: Нэрс,чонын элэг хүрэн манжинг хатааж цай хийх, , Луувангаар нухаш хийх мөн түүнчлэн сүү цагаан идээ боловсруулж цех байгуулж ажиллах,

Компанийг бизнесийн шинэ салбарт ажиллах, удирдлагын орон тоо бүтцийг оновчтой болгоно

3. Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Хөвсгөл, Говь-Алтайд бараа бүтээгдэхүүн борлуулах ажлыг системтэй хийж шинэ зах зээлд бараа бүтээгдэхүүнээ гаргана
4. Газар тариалан туслах аж ахуйн ажлыг эрчимжүүлэх нэмэгдүүлэх ажлыг хийх
5. Туршилтын цехүүдийг байнга ажиллуулж бүтээгдэхүүнийг шинэчлэн сайжруулах, хаяг загварыг өөрчлөх, оюуны өмчөө баталгаажуулах чиглэлд онцгой анхаарч, Шинээр ноосон нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэх, барилга засвар угсралтын ажил эрхлэх, Жимсний нэрмэл архи үйлдвэрлэх, цагаан идээ боловсруулах чиглэлээр ажиллаж үйлдвэрлэлийнхээ хэмжээг нэмэгдүүлэх зорилтуудыг тавиж байна.

Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

Мэдээлэл аудитын компаниар баталгаажуулсан Завханбаялаг ХК-ны 2020 оны санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга, дүгнэлтийн хамтаар 2021 оны 02-р сарын 09-ны А/05,06 тоот албан бичгээр Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж олон нийтэд мэдээлж ил тод байдлыг хангаж, Татвар НД-ын байгууллагуудад тайлан тооцоог цаг хугацаанд нь өгч, хөндлөнгийн Аудитын байгууллагаар тайлан, санхүүгийн үйл ажиллагаандаа шалгалт хийлгэж дүгнэлт гаргуулж санхүүгийн үр дүнг нийтэд ил болгов.

2020 онд Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл гэрээ хийгдээгүй байна. Аудитын дүгнэлт, компаний 2020 оны санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.